

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн мэдээллийн аюулгвй байдлын чиглэлээр судалгаа хийдэг, вйл ажиллагаа явуулдаг байгууллага, эрдэмтэн судлаачидтай хамтран **“Мэдээллийн аюулгвй байдал: онол, практикийн тулгамдсан асуудал”** сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний хурлыг ҮБХИС-ийн Олон улсын хурлын танхимд 2018 оны 5 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулж явууллаа.

Олон улсын эрдэм шинжилгээний хуралд ОХУ-ын ЗХЖШ-ын Академийн Аюулгвй байдлын тэнхмийн ахлах багш, доцент, шинжлэх ухааны доктор, хурандаа Александр Георьентевич Лихоносков, ОХУ-ын Москва хотын Холбоо, Мэдээллийн технологийн их сургуулийн Мэдээллийн аюулгвй байдлын тэнхмийн дэд профессор Осин Андрей Владимирович, БНХАУ-ын Орчин үеийн олон улсын харилцааны хүрээлэнгийн судлаач, профессор Зао Чен, БНСУ-ын Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Цэрэг, стратеги судлалын товийн профессор Мvн Жан Ёл болон Япон Улсын Олон улсын харилцааны хүрээлэнгийн судлаач Эдвард Майкл Шварк нарын нийт 5 гадаадын судлаач оролцлоо.

Мон мэдээллийн аюулгвй байдлын чиглэлээр вйл ажиллагаа явуулдаг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Цагдаагийн еронхий газар, Тагнуулын еронхий газар, Хил хамгаалах еронхий газар, Онцгой байдлын еронхий газар, Мэдээллийн технологийн үндэсний парк, Улсын бүртгэл, оюуны өмчийн еронхий газар, Стандарт, хэмжил зvйн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Монгол шуудан хувьцаат компани, Монголын олон нийтийн радио телевиз, Датаком ХХК болон энэ чиглэлээр сургалт, судалгаа явуулдаг Үндэсний тагнуулын академи, Стратегийн судалгааны хүрээлэн, Олон улсын харилцааны хүрээлэн, Хууль зvйн үндэсний хүрээлэн, Геополитик судлалын хүрээлэн, Зvүн хойд Ази судлалын хүрээлэн, Гамшиг судлалын хүрээлэн, МУИС, Хvмvнлэгийн ухааны их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Хууль сахиулахын их сургууль, Хүрээ дээд сургуулийн 100 гаруй эрдэмтэн судлаачид оролцож, мэдээллийн аюулгвй байдлын оноогийн байдал, шинэ нохцол дэх кибер орон зай, тулгарч буй бэрхшээл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сvлжээ ашиглан нийгэм, хvний оюун санаанд нолоолох мэдээллийн дайны тухай болон улс орнуудын мэдээллийн аюулгвй байдлын чиглэлээр баримталж буй бодлого, вйл ажиллагааны туршлага, сургамжийн талаар хэлэлцлээ.